



БАЯНХОНГОР АЙМАГ
ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 14 өдөр

Дугаар А/145

Эмээлтөлгой

Техникийн хяналтын үзлэг, тээврийн хэрэгслийн албан
татвар хураалтын ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 "Авто тээврийн тухай" хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/173 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тээврийн хяналтын үзлэг, албан татвар хураалтын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай

Ажлын хэсгийн ахлагч:	Д.Ганзориг	(Засаг даргын орлогч)
Гишүүдэд:	Б.Алтангадас	(Цагдаагийн тасгийн дарга)
	Б.Амарзаяа	(Хэсгийн төлөөлөгч)
	С.Батаа	(Тасгийн цагдаа)
	Ч.Цэдэвсүрэн	(1-р багийн Засаг дарга)
	Ж.Должинсүрэн	(2-р багийн Засаг дарга)
	А.Лхагвадорж	(3-р багийн Засаг дарга)
	Н.Ганжаргал	(4-р багийн Засаг дарга)
Нарийн бичгийн дарга:	Ш.Ичинхорлоо	(Татварын улсын байцаагч)

2.Сумын хэмжээнд бүртгэлтэй нийт тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт хамруулах үйл ажиллагааг чанартай зохион байгуулж, гаалийн бүртгэлтэй мотоциклийг бүртгэлжүүлж, холбогдох стандартуудын шаардлагыг хангуулж, ашиглах боломжгүй тээврийн хэрэгслийг улсын бүртгэлээс хасуулах ажлыг аймгийн Автотээврийн төвтэй хамтран зохион байгуулахыг комиссын дарга болон нийт гишүүдэд үүрэг болгосугай.

3.Сумын иргэд, байгууллагын эзэмшилд байгаа бүртгэлтэй автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, орон

нутгийн зам ашигласны төлбөр хураамжийг холбогдох хууль тогтоомжийн дагуу 2022 оны 06 дугаар сарын 01-ний дотор хураан төсөвт төвлөрүүлж, үр дүнг тайлагнаж ажиллахыг комиссын дарга (Д.Ганзориг), нарийн бичгийн дарга (Ш.Ичинхорлоо) нарт тус тус даалгасугай.

4.Техникийн хяналтын үзлэгийн үеэр үзлэгт орох тээврийн хэрэгслийг эмх цэгцтэй дарааллын дагуу оруулан хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, цаашид техникийн хяналтын үзлэгт хамрагдсан байдал, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, орон нутгийн зам ашигласны төлбөр төлөлт, жолоочийн хариуцлагын даатгалд хамрагдсан байдалд бүтэн жилийн турш хяналт шалгалтыг тасралтгүй хийж, зөрчлийг тухай бүр арилгуулахыг Цагдаагийн тасгийн дарга (Б.Алтангадас)-т даалгасугай.

5.Өөрсдийн багийн иргэдийг тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгт бүрэн хамруулах ажилд идэвх санаачилга гаргаж ажиллахын зэрэгцээ албан татвар хураалт, жолоочийн хариуцлагын даатгал төлөлт, банкуудын гүйлгээ хийгдэх үед ард иргэдийн дунд бөөгнөрөл үүсгэхгүй байх тал дээр анхаарч ажиллахыг багийн Засаг нарт үүрэг болгосугай.

6.Хүн малын гоц халдварт өвчин тархахаас урьдчилан сэргийлэх чиглэлээр ард иргэдэд мэдээлэл өгч, үзлэгийн үеэр ашиглах ажлын байрууд, тээврийн хэрэгсэлд ариутгал халдваргүйжүүлэлт хийж, иргэн бүрийн амны хаалтын хэрэглээнд хяналт тавьж ажиллахыг Сумын эрүүл мэндийн төвийн дарга (Г.Алтантуяа), Мал эмнэлгийн улсын байцаагч (С.Жаргалсайхан) нарт тус тус үүрэг болгосугай.

7.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Өнөрбаяр)-т үүрэг болгосугай.

ДАРГА  Д.МӨНХЖАРГАЛ

